

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг тус тус баримтлан 2016 онд тус яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг гаргав. Үүнд:

Нэг. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв 11-11–ээр дамжуулан Зам, тээврийн хөгжлийн яаманд 2016 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд нийт 1950 хандалт бүртгэгдсэнээс 1888 хаагдсан, 56 нь судлагдаж байгаа ангилалтай байна. Хариуг 96.82 хувь өгсөн бөгөөд санал хүсэлтийг ангилж үзвэл:

д/д	Төрөл	Тоо
1.	Санал хүсэлт	1370
2.	Гомдол	374
3.	Шүүмжлэл	193
4.	Талархал	11
5.	Өргөдөл	2
Нийт		1950

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн яаманд 2016 онд иргэдээс нийт 503 өргөдөл, хүсэлт ирснээс шийдвэрлэж хариу өгсөн 469, шийдвэрлэхээр судлан хяналтад байгаа 16, хуулийн хугацаа нь болоогүй 18 өргөдөл байна.

2016 оны байдлаар иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл,
гомдол санал, хүсэлт

Д/д	Яам, агентлагийн нэрс	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Бусад хэлбэрээр
1.	Зам, тээврийн хөгжлийн яам	503	503	1950	-	-
2.	Иргэний нисэхийн ерөнхий газар	827	827	-	-	-
Нийт		1330	1330	1950	-	-

Зам, тээврийн хөгжлийн яамны 2016 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

д/д	Яам, агентлагийн нэрс	Ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт
-----	-----------------------	----------------------------	------------------------	-------------------------------	------------------	-------------

1.	Зам, тээврийн хөгжлийн яам	503	469	-	34	93,24 %
2.	Иргэний нисэхийн ерөнхий газар	827	752	-	75	91 %
Нийт		1330	916	-	109	92,12 %

2016 онд ирүүлсэн өргөдөл гомдолд зонхилж тавьсан асуудал

Д/д	Яам, агентлагийн нэрс	Агуулга
1.	Зам, тээврийн хөгжлийн яам	<p>Иргэдээс ирсэн нийт 503 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс 45.92 % буюу 231 өргөдөл үйл ажиллагаатай холбоотой, 54.07% буюу 272 өргөдөл тэтгэмж туслалцаа, ажилд орох, гарах, тэмдэг нөхөн олгуулах хүсэлт зонхилж байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилд орох, гарах, чөлөө хүссэн – 85 • Үйл ажиллагаатай холбоотой – 231 • Тэтгэмж хүссэн–34 • Бусад-153
2.	Иргэний нисэхийн ерөнхий газар	<p>Иргэдээс ирсэн нийт 827 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс 27.93 % буюу 231 өргөдөл үйл ажиллагаатай холбоотой, 1.09% буюу нь 9 санал хүсэлт, 1,57 % буюу 13 гомдол ирсэн байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилд орох, гарах, чөлөө хүссэн –252 • Үйл ажиллагаатай холбоотой – 231 • Орон сууцны дэмжлэг хүссэн–73 • Сургууль, эмчилгээний тэтгэмж хүссэн-99 • Бусад-172
3.	Нийт	<p>Нийт 1330 өргөдөл гомдлыг төрлөөр нь ангилбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Өргөдөл 1278 /96,0%/ 2. Санал-хүсэлт -22 /1,65 %/ 3. Гомдол -30 /2,25 %/ 4.Шүүмжлэл -0 5.Талархал,мэдээлэл – 0 <p>Нийт 1330 өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзвэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагаатай холбоотой (Авто тээвэр, авто зам, төмөр зам, нисэх) -462 /34,73%/ 2. Сургууль, эмчилгээний зардлын тэтгэмж хүссэн – 121 /9,09%/ 3. Ажилд орох, гарах, чөлөө хүссэн – 337 /25,33% / 4. Орон сууцны үнийн дэмжлэг хүссэн –85 /6,39%/ 5. Бусад -325 /24,43%/

Тайлангийн хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлагаас иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийн дагуу Сайд 430, Төрийн нарийн бичгийн дарга 215 иргэнтэй уулзсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яаманд 2016 онд иргэдээс ирүүлсэн 503 өргөдөл, санал, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн 469-д нь хариуг хүргүүлж ажилласан.

Бусад төрийн байгууллагаас уламжлан ирсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Дүгнэлт:

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв 11-11-ээр дамжуулан ирсэн хандалтын шийдвэрлэлт 96,82 хувь, тус яаманд ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93,24 хувийн биелэлттэй байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ